



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

᠔᠔᠘4 · ᠐᠔ · ᠔᠔᠒ № 8᠐

танай _____ -ны № _____ -т

АЛДАРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТӨМӨРХҮҮ-Д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын шагналд 3.080.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авч, эмэгтэйчүүдийн баяр, залуучуудын спортын наадмын хувцас, байр, хоолны зардалд 2,000.0 мянган төгрөг, сумын төрийн албан хаагчдыг Улаанбаатар хотод чадавхжуулах сургалтад хамруулахаар автобусны зардалд 5,000.0 мянган төгрөг зарцуулж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1,200.0 мянган төгрөгийн сургалтын зардал гаргаж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.5. “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн

Асуудлыг онцолсон хэсэг

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 6,752.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 162,438.0 мянган төгрөгийн автомашин шилжүүлэн авч, 230,580.2 төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн байна. Үлдэх өртөггүй 348.381.7 мянган төгрөгийн 90 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 4,569.4 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг шийдвэргүйгээр олгосон, 3,369.8 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 355.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь баяр наадмын талбай, түмний өргөө, сумын төвийн худаг, мал эмнэлгийн үйлчилгээний цэг, аялал жуулчлалын бааз, цэцэрлэгийн хуучин барилга, 75 хүүхдийн дотуур байрны газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,441,945.0</u>	<u>52,970,907.4</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,300,000.0
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	4,300,000.0
3121	Төгрөг	-	4,300,000.0
31211	Төрийн сангийн харилцах	-	4,300,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	33,839,445.0	48,670,907.4
351	Түүхий эд материал	6,617,455.0	6,526,955.0
35110	Тусгай зориулалттай материал	6,617,455.0	6,526,955.0
354	Хангамжийн материал	27,221,990.0	42,143,952.4
35410	Бичиг хэргийн материал	266,020.0	629,180.0
35420	Аж ахуйн материал	7,257,370.0	7,004,470.0
35440	Түлш, шатах тослох материал	-	6,158,803.4
35450	Барилгын засварын материал	3,000.0	3,000.0
35470	Бусад хангамжийн материал	19,695,600.0	28,348,499.0
36	НӨӨЦИЙН БАРАА	1,602,500.0	-
36100	Барааны нөөц	1,602,500.0	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>529,091,002.2</u>	<u>866,683,037.8</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	529,091,002.2	866,683,037.8
392	Биет хөрөнгө	499,072,302.2	836,994,337.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	741,464,226.5	787,216,946.5
39202	Хуримтлагдсан элэгдэл	(311,571,225.5)	(352,583,734.6)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,694,800.0	272,132,696.7
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,395,840.4)	(62,811,829.9)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	262,328,191.0	392,908,391.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(225,017,729.9)	(234,206,972.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,551,016.0	44,551,016.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,785,662.1)	(30,379,352.9)
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,148,638.0	34,148,638.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,058,566.4)	(14,695,915.2)
39217	Ном	714,455.0	714,455.0
393	Биет бус хөрөнгө	30,018,700.0	29,688,700.0
39301	Програм хангамж	2,602,000.0	2,602,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,804,500.0)	(2,134,500.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,221,200.0	29,221,200.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>564,532,947.2</u>	<u>919,653,945.2</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>623,841.0</u>	<u>36,130.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	623,841.0	36,130.0
413	Өглөг	623,841.0	36,130.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	207,341.0	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	384,200.0	-
4136	Бусад өглөг	32,300.0	36,130.0

41361	Байгууллагад төлөх өглөг	32,300.0	36,130.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	563,909,106.3	919,617,815.2
51	Засгийн газрын хувь оролцоо	563,909,106.3	919,617,815.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,989,594.7	448,989,594.7
51101	Өмч: - төрийн	448,989,594.7	448,989,594.7
512	Хуримтлагдсан үр дүн	50,161,792.8	405,870,501.8
51210	Өмнөх үеийн үр дүн	70,081,585.3	50,161,792.8
51220	Тайлант үеийн үр дүн	(19,919,792.5)	355,708,709.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,757,718.7	64,757,718.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	564,532,947.2	919,653,945.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	472,847,000.0	948,349,884.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	406,918,996.8
120	Нийтлэг татварын бус орлого	-	406,918,996.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	401,018,996.7
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	401,018,996.7
120009	Бусад орлого	-	5,900,000.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,847,000.0	541,430,887.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,700,000.0	20,687,987.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	144,700,000.0	20,687,987.2
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,147,000.0	520,742,900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,147,000.0	520,742,900.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	492,566,792.5	592,080,524.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,566,792.5	592,080,524.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482,168,826.4	535,854,558.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,039,429.3	311,418,601.8
210101	Үндсэн цалин	175,517,667.6	234,601,597.6
210102	Нэмэгдэл	25,798,073.3	65,854,157.5
210104	Урамшуулал	4,723,688.5	10,962,846.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,756,936.4	43,174,148.9
210201	Тэтгэврийн даатгал	17,743,948.6	29,485,800.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,106,813.0	3,281,548.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,631,688.0	2,775,100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	380,031.6	693,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,894,455.3	6,937,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,445,658.6	37,832,943.8
210301	Гэрэл, цахилгаан	3,867,774.6	4,977,366.8
210302	Түлш, халаалт	31,577,884.0	32,855,577.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,658,880.0	36,372,816.6
210401	Бичиг хэрэг	2,777,800.0	5,497,420.0
210402	Тээвэр, шатахуун	15,815,200.0	23,348,196.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,883,880.0	2,580,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	182,000.0	4,947,100.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,977,450.0	3,423,550.0
210604	Урсгал засвар	2,977,450.0	3,423,550.0
2107	Томилолт, зочны зардал	1,944,000.0	7,098,000.0
210702	Дотоод албан томилолт	1,944,000.0	7,098,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	742,852.0	638,180.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	377,300.0	531,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,000.0	61,680.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	265,000.0	45,000.0
210807	Газрын төлбөр	46,552.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	187,603,620.0	95,896,317.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	126,772,000.0	32,168,136.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,100.0	1,549,400.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,752,520.0	62,178,781.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,397,966.1	56,225,965.8
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,397,966.1	56,225,965.8
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,397,966.1	56,225,965.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,719,792.5)	356,269,360.1
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(19,719,792.5)	356,269,360.1

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	472,847,000.0	547,330,887.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,900,000.2
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,900,000.2
120009	Бусад орлого	-	5,900,000.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,847,000.0	541,430,887.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,700,000.0	20,687,987.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	144,700,000.0	20,687,987.2
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,147,000.0	520,742,900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,147,000.0	520,742,900.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	472,647,000.0	535,717,516.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	472,647,000.0	535,717,516.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,249,033.9	479,491,550.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,977,430.7	311,438,591.7
210101	Үндсэн цалин	173,455,669.0	234,621,587.4
210102	Нэмэгдэл	25,798,073.3	65,854,157.5
210104	Урамшуулал	4,723,688.5	10,962,846.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,584,800.0	43,361,500.0
210201	Тэтгэврийн даатгал	18,757,600.0	29,485,800.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,206,700.0	3,468,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,765,500.0	2,775,100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	441,400.0	693,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,413,600.0	6,937,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,029,851.1	38,032,943.8

210301	Гэрэл, цахилгаан	3,867,774.6	4,977,366.8
210302	Түлш, халаалт	37,162,076.5	33,055,577.0
2104	Хангамж, бараа материалын зардал	20,989,200.0	32,438,880.0
210401	Бичиг хэрэг	2,324,300.0	5,504,780.0
210402	Тээвэр, шатахуун	15,715,200.0	22,947,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,949,700.0	2,870,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,117,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,228,300.0	4,789,800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,400,000.0	-
210604	Урсгал засвар	2,828,300.0	4,789,800.0
2107	Томилолт, зочны зардал	1,944,000.0	7,098,000.0
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,944,000.0	7,098,000.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,394,952.0	726,180.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,091,000.0	531,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,000.0	61,680.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.0	133,000.0
210807	Газрын төлбөр	46,552.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,100,500.0	41,605,655.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,797,100.0	39,402,255.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.0	2,203,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,397,966.1	56,225,965.8
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,397,966.1	56,225,965.8
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,397,966.1	56,225,965.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	200,000.0	11,613,371.1
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	6,752,720.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,752,720.0
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,752,720.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	6,752,720.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(6,752,720.0)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	200,000.0	4,860,651.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,300,000.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,989,594.7	64,757,718.7	70,081,585.3	583,828,898.8
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,989,594.7	64,757,718.7	70,081,585.3	583,828,898.8
C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-19,919,792.5	-19,919,792.5
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,989,594.7	64,757,718.7	50,161,792.8	563,909,106.3
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,989,594.7	64,757,718.7	50,161,792.8	563,909,106.3
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,989,594.7	64,757,718.7	50,161,792.8	563,909,106.3

D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	355,708,709.0	355,708,709.0
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,989,594.7	64,757,718.7	405,870,501.8	919,617,815.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	520,772,200.0	464,716,934.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	520,772,200.0	464,716,934.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	520,772,200.0	464,716,934.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,892,200.0	311,438,591.7
210101	Үндсэн цалин	277,146,500.0	234,621,587.4
210102	Нэмэгдэл	69,745,700.0	65,854,157.5
210104	Урамшуулал	-	10,962,846.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,361,500.0	43,361,500.0
210201	Тэтгэврийн даатгал	29,485,800.0	29,485,800.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,468,900.0	3,468,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,775,100.0	2,775,100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	693,800.0	693,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,937,900.0	6,937,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,215,000.0	36,672,082.7
210301	Гэрэл, цахилгаан	4,002,800.0	3,616,505.7
210302	Түлш, халаалт	33,212,200.0	33,055,577.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,066,800.0	32,041,880.0
210401	Бичиг хэрэг	5,469,700.0	5,504,780.0
210402	Тээвэр, шатахуун	22,687,000.0	22,687,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,910,100.0	2,850,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.0	1,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,789,800.0	5,789,800.0
210604	Урсгал засвар	5,789,800.0	5,789,800.0
2107	Томилолт, зочны зардал	4,378,000.0	4,378,000.0
210702	Дотоод албан томилолт	4,378,000.0	4,378,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,659,400.0	726,180.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,129,700.0	531,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.0	61,680.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.0	133,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,409,500.0	30,308,900.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,206,100.0	28,105,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,203,400.0	2,203,400.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	473,538,500.0	464,716,934.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	473,538,500.0	464,716,934.4
122005	Орон нутгийн төсвөөс	473,538,500.0	464,716,934.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,700,000.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	20,127,336.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,127,336.08
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,127,336.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,360,861.08
210301	Гэрэл, цахилгаан	1,360,861.08
2104	Хангамж, бараа материалын зардал	397,000.00
210402	Тээвэр, шатахуун	260,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,720,000.00
210702	Дотоод албан томилолт	2,720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,649,475.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,649,475.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	20,127,336.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,127,336.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,127,336.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,127,336.08

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэл:

- Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын зорилго: “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилго, зорилт чиг үүргийн хүрээнд ажилладаг байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.2 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Татварын ерөнхий хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

9. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Сумын ЗДТГ-ын дэргэд дотоод аудитын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 355,121.0 мянган төгрөгөөр буюу 37.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,300.0	4,300.0
Бараа материал	35,441.9	48,670.9	13,229.0
Үндсэн хөрөнгө	529,091.0	866,683.0	337,592.0
Нийт хөрөнгө	564,532.9	919,653.9	355,121.0
Богино хугацаат өр төлбөр	623.8	36.1	(587.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	563,909.1	919,617.8	355,708.7

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	564,532.9	919,653.9	355,121.0
---------------------------------------	-----------	-----------	-----------

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,300.0 байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 33,839.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 48,876.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 8,000.9 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 43,647.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 48,670.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,831.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 6,752.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 393,018.1 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 696,812.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 62,178.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 355,708.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 347,709.8 мянган төгрөг, нийт зарлагыг 347,709.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардал нэмж батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 519,302.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 464,716.9 мянган төгрөг буюу 89.5 хувьтай байна. Албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл 31,718.7 мянган төгрөг, баг хорооны цалин 5,698.2 төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 17,100.6 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	368,191.9	336,473.1	31,718.7	91.4%
80106	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	105,305.0	99,606.8	5,698.2	94.6%

80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	600.0	531.5	68.5	88.6%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	40,306.1	23,205.5	17,100.6	57.6%
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	4,900.0	4,900.0	0.0	100%
НИЙТ		519,302.9	464,716.9	54,586.0	89.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 20,688.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 20,127.3 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, шуудан холбоо, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 560.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Бэлчээрийн худаг засварлах	10,000,000	10,000,000
ДҮН			10,000,000	10,000,000

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 564,532.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,468.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.351.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 919,653.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,794.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10.346.1 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 42 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын шагналд бэлэг дурсгалын зүйл худалдан авч, эмэгтэйчүүдийн баяр, залуучуудын спортын наадмын хувцас, байр, хоолны зардал, сумын төрийн албан хаагчдыг Улаанбаатар хотод чадавхжуулах сургалтад хамруулахаар автобусны зардалд гаргаж, батлагдсан төсвийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 11,280.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагч ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 487,122.1 мянган төгрөгийн зөрчилд 4 заалт зөвлөмж, 5,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнөөс 491,715.6 мянган төгрөгийн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж, 406.5 мянган төгрөгийн 1 заалт зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өглөө.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	5,000.0	1	5,000.0	100%
Зөвлөмж	4	487,122.1	3	486,715.6	99.9%
Нийт дүн	5	492,122.1	4	491,715.6	99.9%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 263,160.5 мянган төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

Мөнгөн гүйлгээний тайланд 6,100.0 мянган төгрөгийн орлогыг, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан 15,578.3 мянган төгрөгийн зарлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, үлдэгдлээр тайлагнасан, тайлант онд худалдаж авсан 6,752.7 мянган төгрөгийн хөрөнгө, Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 40,000.0 мянган төгрөгийн баяр наадмын талбай, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 50,000.0 мянган төгрөгийн мал угаалгын автомашин болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 8,000.9 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй, 3,648.4 мянган төгрөгийн бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 367,956.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 4,569.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,635.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,369.8 мянган төгрөгийн зөрчил болон үлдэх өртөггүй 348.381.7 мянган төгрөгийн 90 нэр төрлийн хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчилж тогтоогоогүй, газрын нэгдсэн санд бүртгэлтэй газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй зөрчилд 3 заалт зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 367,956.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 354,161.6 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Сумын Засаг даргын орлогчид аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан бичгийг үндэслэн ажил орлон гүйцэтгэсний нэмэгдлийг 40 хувиар тооцон олгосон 2,775.4 мянган төгрөгийн, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний цалинг 286.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон, төрийн алба хаасан хугацааны болон орон нутгийн нэмэгдлийг шийдвэргүй олгосон 1,507.0 мянган төгрөгийн, нийт 4,569.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын шагналд 3.080.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авч, эмэгтэйчүүдийн баяр, залуучуудын спортын наадмын хувцас, байр, хоолны зардалд 2,000.0 мянган төгрөг, сумын төрийн албан хаагчдыг Улаанбаатар хотод чадавжуулах сургалтад хамруулахаар автобусны зардалд 5,000.0 мянган төгрөг зарцуулж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1,200.0 мянган төгрөгийн сургалтын зардал гаргаж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан болон Албан хаагчдын 2023 оны 07 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 355.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд 2 албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалт, золголт болон сайн малчдын шагнал гардуулах, УБ хотод аймгийн 100 жилийн ойн ажлаар явахад 2.310.0 мянган төгрөгийн шатахууныг албан бус хэрэгцээнд зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан, мөн Улсын баяр наадмын үйл ажиллагаанд 1.059.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1-д “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоох” гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, албан бус хэрэгцээнд шатахуун зарцуулахгүй байх, Улсын баяр наадмын зардалд байгууллагын төсвөөс нэмж зардал гаргахгүй байх;

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд үлдэх өртөггүй 348.381.7 мянган төгрөгийн 90 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж

шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Баяр наадмын талбай, түмний өргөө, сумын төвийн худаг, мал эмнэлгийн үйлчилгээний цэг, аялал жуулчлалын бааз, цэцэрлэгийн хуучин барилгын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Баяр наадмын талбай, түмний өргөө, сумын төвийн худаг, мал эмнэлгийн үйлчилгээний цэг, аялал жуулчлалын бааз, цэцэрлэгийн хуучин барилгын барилга байгууламжуудын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлээний тайланд ахмадын сан болон нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг тусгаагүй орхигдуулсан	1	6,100.0	1	6,100.0			1	6,100.0				
Бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн.	1	3,648.4	1	3,648.4			1	3,648.4				
Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан зарлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, үлдэгдлээр тайлагнасан	1	15,578.3	1	15,578.3			1	15,578.3				
Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 8,000.9 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй	1	8,000.9	1	8,000.9			1	8,000.9				
Тайлант онд худалдаж авсан 6,752.7 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй	1	6,752.7	1	6,752.7								
Үнэ төлбөргүйгээр шилжиж ирсэн 133,080.2 мянган төгрөгийн хөрөнгийг тайлант онд худалдаж авснаар бүртгэж, тайлагнасан	1	133,080.2			1	133,080.2	1	133,080.2				
Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн баяр наадмын талбай, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн мал угаалгын автомашиныг данс бүртгэлд тусгаагүй	1	90,000.0	1	90,000.0			1	90,000.0				
Дүн	7	263,160.5	6	130,080.3	1	133,080.2	7	263,160.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Төлбөрийн акт		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан хаагчдын 2023 оны 07 сард НДШ-ийг 355.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	355.5	1	355.5			
Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын шагналд бэлэг дурсгалын зүйл худалдан авч, эмэгтэйчүүдийн баяр, залуучуудын спортын наадмын хувцас, байр, хоолны зардал, сумын төрийн албан хаагчдыг Улаанбаатар хотод чадавхжуулах сургалтад хамруулахаар автобусны зардал гаргаж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1,200.0 мянган төгрөгийн сургалтын зардал гаргаж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, батлагдсан төсвийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан	1	11,280.0	1	11,280.0			
Сумын Засаг даргын орлогчид аймгийн ЗДТГ-ын даргын албан бичгийг үндэслэн ажил орлон гүйцэтгэсний нэмэгдэл тооцон олгосон, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний цалинг илүү тооцож, төрийн алба хаасан	1	4,569.4	1	4,569.4			

